

**ТӨВ БАНКНААС САНХҮҮЖИЛТ ОЛГОХОД БАРЬЦААЛАХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

1. Төв банкнаас (Монголбанк) санхүүжилт олгоход санхүүжилтийн төрлөөс хамаарч дараахь төрлийн активыг барьцаа хөрөнгө болгож болно. Үүнд:

Санхүүжилтийн төрөл	Барьцаа хөрөнгө
1. Нээлттэй захын үйл ажиллагаа	
1.1 Төв банкны репо арилжаа	Төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас, Засгийн газрын вексель
2. Санхүүжилтийн байнгын хэрэгсэл	
2.1 Банкны хүсэлтээр олгогдох репо санхүүжилт	Төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас, Засгийн газрын вексель, МИК-ийн үнэт цаас ¹
3. Барьцаат зээл	Төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас, Засгийн газрын вексель, МИК-ийн үнэт цаас, банкны хэвийн зээл
4. Өдрийн репо	Төв банкны үнэт цаас

2. Төв банкнаас санхүүжилт олгоход барьцаалах активын эрсдэлийн хямдруулалтын хувийг дараахь байдлаар тооцно. Үүнд

2.1 Үнэт цаасны хувьд эрсдэлийн хямдруулалтын хувийг дараахь хүснэгтийн дагуу тооцно:

Барьцаа хөрөнгө	Эрсдэлийн хямдруулалт (зах зээлийн үнийн хувиар)		
	Хугацаа		
	0-3 жил	3-5 жил	5-аас дээш жил
Төв банкны үнэт цаас	1.5 хувь		
Засгийн газрын үнэт цаас, Засгийн газрын вексель	3.5 хувь	7 хувь	10 хувь
МИК-ийн үнэт цаас	30 хувь		

2.2 Банкны хэвийн зээлийн хувьд эрсдэлийн хямдруулалтын хувийг дараахь хүснэгтийн дагуу тооцно:

Банкны эрсдэлийн үнэлгээ ²	Эрсдэлийн хямдруулалт	
	6 сар хүртгэлх хугацаатай зээл	6 сараас дээш хугацаатай зээл
3 хувь хүртэл	20%	30%
3-5 хувь хүртэл	25%	35%
5-7 хувь хүртэл	30%	40%
7 хувиас дээш	40%	50%

¹ Монголын Ипотекийн корпорацийн (МИК) 2009 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлсэн үнэт цаас

² Монголбанкны Ерөнхийлөгчийн 2004 оны 226 дугаар тушаалаар баталсан “Зээлийн эрсдэл тооцох зөвлөмж”-ийг үндэслэн Хяналт, шалгалтын газраас тогтоосон арилжааны банкуудын эрсдэлийн үнэлгээ

3. Төв банкнаас олгох санхүүжилтийн хэмжээг дараахь томъёогоор тооцож, зуутын орон хүртэл бүхэлчилнэ.

$$RA = \frac{MV}{\left(1 + \frac{IM}{100}\right)}$$

RA= Санхүүжилтийн хэмжээ

MV= Барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэ³

IM= Эрсдэлийн хямдруулалтын хувь

³ Барьцаа активын зах зээлийн үнийг санхүүгийн захаас шууд тооцох боломжгүй тохиолдолд тухайн активын үнийг шугаман хувиргалтын (linear extrapolation) аргаар тооцоолно.